



КОРОНАВИРУС БА ЭДИЙН ЗАСАГ



УЛААНБААТАР ХОТ
2020 он

Коронавируст халдварын дэгдэлттэй холбогдуулан Монгол Улсын өнөөгийн эдийн засаг, нийгмийн төлөв байдлыг танилцуулъя.

ҮСХ-ноос 2020 оны 4-р сарын 13-ны өдөр тархаасан нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллээр 2020 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс

- улсын нэгдсэн төсвийн орлого 8.6 хувиар,
- экспорт 41.5 хувиар,
- импорт 9.7 хувиар,
- аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 19.9 хувь, тэр дундаа уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 29.8 хувиар,
- бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 33.4 хувиар, зорчигч 31.4 хувиар,
- жуулчдын тоо 51.6 хувиар,
- бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 10.8 хувиар,
- халдварт өвчнөөр өвчлөгчид 7.1 хувиар,
- бүртгэгдсэн гэмт хэрэг 19.2 хувиар тус тус буурч, харин
- нийт хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 25.9 хувиар,
- улсын нэгдсэн төсвийн зарлага 19.3 хувиар,
- үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн тоо 9.9 хувиар тус тус өсжээ.



1. УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны нийт орлогыг 12.9 их наяд төгрөг байхаар баталсан. Үүний 3.2 их наяд төгрөгийг уул уурхайн салбарын орлого, 3.5 их наяд төгрөгийг импорт, 5.1 их наяд төгрөгийг эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлийн орлого, 1.1 их наяд төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр тооцсон байна.



Өөрөөр хэлбэл, төсвийн орлогын гуравны нэгийг уул уурхайн бүтээгдэхүүн буюу нүүрс, зэсийн баяжмалыг БНХАУ-д экспортолж, бүрдүүлэхээр тооцжээ.¹

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 2.2 их наяд төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.


Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны 3 дугаар сард 760.2 тэрбум төгрөг болж өмнөх сараас 63.5 (9.1%) тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж

¹ https://mof.gov.mn/files/uploads/article/%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%B2_2020-pdf1.pdf

төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 860.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 12.6 (1.1%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 86.0 хувийг татварын орлого бүрдүүлж байгаа бөгөөд татварын нийт орлого 2020 оны эхний улиралд 1.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 58.9 (3.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд нийгмийн даатгалын орлого 20.5 (4.7%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 11.2 (2.9%) тэрбум төгрөг, хөрөнгийн албан татвар 4.5 (16.3%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч бусад татвар, төлбөр хураамжийн орлого 63.9 (29.9%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 33.9 (15.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг 2. Улсын нэгдсэн төсвийн татварын орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар



Нийт татварын орлогод бусад татварын эзлэх хувь өмнөх оны мөнх үеэс 2.8 пункт, онцгой албан татвар 1.4 пункт, гадаад үйл ажиллагааны орлого 0.1 пунктээр буурсан хэдий ч нийгмийн даатгалын орлого 1.8 пункт, орлогын албан татварын эзлэх хувь 1.3 пункт, нэмэгдсэн өртгийн албан 1.2 пунктээр өссөн байна.

НӨАТ-ын орлого 2020 оны 2-р сард 3.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 97.6 хувиар буурч байсан бол энэ оны 3-р сард 190.3 тэрбум төгрөг болж, 75.0 хувиар өссөнөөр НӨАТ-ын орлого эхний улиралд 392.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өссөн байна.


Хүснэгт 1. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого, сая төгрөг²

Үзүүлэлт	2019			2020			2020* I-III 2019 I-III
	II	III	I-III	II	III*	I-III*	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	151 537.2	108 751.9	381 552.6	3 696.0	190 266.5	392 762.5	102.9

Улсын нэгдсэн төсвийн зарлагын өсөлтөд урсгал зардал 332.1 (18.4%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 73.0 (43.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардал 90.8 хувь, хөрөнгийн зардал 10.3 хувь, эргэж төлөгдөх зээлийг хассан цэвэр зээл -1.0 хувийг эзэлж байна.

Зураг 3. Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар²



Урсгал зардалд бараа үйлчилгээний зардал 45.2 хувь, урсгал шилжүүлэг 41.9 хувь, хүүгийн зардал 8.7 хувь, татаас 4.1 хувийг эзэлж байна.

² http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0800_002V1

2. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын борлуулалт 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 3.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (35.0%) их наяд төгрөгөөр буурсан ба мод, модон эдлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, химийн бүтээгдэхүүн, тамхи, тавилга, хувцас зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн борлуулалт 1.7-60.2 хувиар буурсан байна.

Харин хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэлийн борлуулалт 21.2 хувь өсжээ. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны эхний улиралд 385.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 28.6 (8.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар

Салбар	2019		2020*		2020* I-III 2019 I-III хувь
	III	I-III	III	I-III	
	тэрбум төгрөг				
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	121.9	356.4	127.7	385.0	108.0
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	15.8	51.7	7.6	32.5	62.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	18.3	52.4	17.8	54.0	102.9
Үр тарианы гурил, малын тэжээл	15.0	50.1	16.5	54.6	109.1
Хүнсний бусад бүтээгдэхүүн	16.6	45.5	16.5	53.9	118.3
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	56.1	156.7	69.3	190.1	121.3

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1.5 (2.9%) тэрбум төгрөгөөр, үр тарианы гурил, малын тэжээл үйлдвэрлэл 4.6 (9.1%) тэрбум төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8.3 (18.3%) тэрбум төгрөгөөр, ундаа үйлдвэрлэл (согтууруулах ундаа ороод) 33.4 (21.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Харин мах, загас, ногоо, тос боловсруулалт өмнөх оны мөн үеэс 19.3 (37.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019		2020*		2020*I-III 2019 I-III хувь
		III	I-III	III	I-III	
Үхрийн мах	т	17.0	138.9	123.8	304.8	2.2 ¹
Хонины мах	т	268.9	1 109.9	85.6	613.2	55.3
Адууны мах	т	985.0	3 191.8	-	342.5	10.7
Ямааны мах	т	33.6	106.9	51.3	490.4	4.6 ¹
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	т	408.6	1 264.7	359.5	1 156.3	91.4
Шингэн сүү	мян.л	3 195.1	9 399.4	3 502.9	10 515.2	111.9
Тараг	мян.л	1 376.9	3 339.4	1 324.6	3 588.8	107.5
Зайрмаг	мян.ш	5 988.6	12 798.4	4 809.2	8 622.5	67.4
Аарц	т	26.9	137.1	45.4	174.2	127.1
Дээд гурил	т	2 175.9	10 307.8	2 979.4	10 835.9	105.1
Нэгдүгээр гурил	т	11 746.0	36 323.4	11 023.5	39 270.7	108.1
Хоёрдугаар гурил	т	1 028.1	3 596.1	2 463.7	6 246.1	173.7
Талх	т	2 548.9	5 960.5	2 302.2	6 380.2	107.0
Нарийн боов	т	1 480.9	4 839.8	1 265.3	5 024.3	103.8
Бялуу	т	276.8	538.6	264.0	591.1	109.8
Жигнэмэг	т	85.2	227.4	44.6	289.4	127.2
Гоймон	т	680.2	1 990.8	361.0	2 096.8	105.3
Бууз, банш	т	388.7	872.8	304.8	688.6	78.9
Савласан ногоон цай	кг	1 857.1	19 066.4	16 567.5	46 221.2	2.4 ¹
Спирт	мян.л	900.7	2 556.4	862.1	2 751.5	107.6
Архи	мян.л	2 055.0	6 615.2	2 076.6	6 564.7	99.2
Шар айраг	мян.л	6 816.1	19 510.6	7 547.9	18 373.9	94.2
Цэвэр ус	мян.л	6 410.2	15 823.1	7 297.3	19 581.1	123.8
Амтат ус, ундаа	мян.л	15 005.2	34 653.5	26 556.8	61 840.7	178.5
Жүүс	мян.л	5 547.2	15 781.1	7 220.1	20 009.1	126.8


¹ Дахин их

Нарийн боов, дээд гурил, гоймон, талх, тараг, спирт, нэгдүгээр гурил, бялуу, шингэн сүү, цэвэр ус, жүүс, аарц, жигнэмэг, хоёрдугаар гурил, амтат ус, ундаа, үхэр, ямааны мах, савласан ногоон цайны үйлдвэрлэл 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 3.8 хувиас 4.6 дахин өссөн байна. Харин архи, шар айраг, хиаман бүтээгдэхүүн, бууз, банш, зайраг, хонь, адууны махны үйлдвэрлэл 0.8-44.7 хувиар буурсан байна.

3. ИНФЛЯЦ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 3 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны эцсээс 2.9 хувь, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар хувиар өссөн байна.

Зураг 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Инфляцын түвшин 2017 оны 3 дугаар сард 3.1 хувь, 2018 оны 3 дугаар сард 6.6 хувь, 2019 оны 3 дугаар сард 6.7 хувь гарч байсан бол 2020 оны 3 дугаар сард 6.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан байна.

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2020 оны 4 дүгээр сарын IV долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 9 нэрийн барааны үнэ (28.1%) тогтвортой, 11 нэрийн барааны үнэ (34.4%) буурсан, 12 нэрийн барааны үнэ (37.5%) өссөн байна.

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> • "Сүү" ХК савласан 0.5 л сүү • Сүү, задгай • "Сүү" ХК тараг, Цөцгийтэй • Талх, "Зууван чех" • Шар будаа • Элсэн чихэр, "Заантай" • Үхрийн мах, цул • Төмс, монгол • Өндөг, ОХУ 	<ul style="list-style-type: none"> • "Алтан Тариа" задгай гурил дээд • "Алтан Тариа" задгай гурил I • "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд • "Алтан Тариа" савласан гурил дээд • "Алтан Тариа" савласан гурил I • Талх, "хөх тарианы хар" • Цагаан будаа, "Заантай" • Цөцгийн тос, Сүү ХК • Үхрийн мах, ястай • Лууван, монгол • Сонгино, хятад 	<ul style="list-style-type: none"> • "Алтан Тариа" савласан гурил II • "Сүү" ХК савласан 1 л сүү • Талх, "Атар" • Ургамлын тос, "Янта" • Ногоон цай, "Сtimo" • Хонины мах, ястай • Хонины мах, цул • Ямааны мах, ястай • Адууны мах, ястай • Байцаа, монгол • Хүрэн манжин, монгол • Алим, фүжи

Хонины ястай махны үнэ 2020 оны 4 дүгээр сарын IV долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад 277 төгрөгөөр (2.8%), хонины цул махны үнэ 441 төгрөгөөр (4.5%) тус тус өссөн байна. Хонины ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 8500 төгрөгөөр, харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 13800 төгрөгөөр худалдаалж байна.

Хүснэгт 4. Нэг килограмм хонины ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	10 025*								

Хонины ястай мах нэг килограмм нь 2020 оны 4 дүгээр сарын IV долоо хоногт дунджаар 10025 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 11793 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 139 төгрөгөөр (1.2%) буурч, харин үхрийн цул махны үнэ тогтвортой байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 9000 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 14500 төгрөг байна.

Хүснэгт 5. Нэг килограмм үхрийн ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 663	11 793*								

Үнийн судалгааны сагс дахь нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг. Энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн нөлөө 35.9 хувь байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр өссөн байна.

Хүснэгт 6. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 3 дугаар сард

Үзүүлэлт	2018 III		2019 III		2020 III	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	6.6	100.0	6.7	100.0	6.4	100.0
Импортын барааны нөлөө	3.0	45.5	2.4	35.8	2.3	35.9

4. ЭКСПОРТ, ИМПОРТ

Манай улс 2020 оны эхний улиралд нийт 121 улстай худалдаа хийсэн ч нийт бараа эргэлтийн 54.5 хувийг БНХАУ эзэлж байна. Нийт бараа эргэлт 2.2 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 860.1 (28.1%) сая америк доллароор буурахад БНХАУ-тай хийсэн нийт экспорт 615.7 (40.5%) сая америк доллароор, импорт 36.1 (9.7%) сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.


Хүснэгт 7. Экспортын гол түнш улсууд, жил бүрийн эхний 3 сарын байдлаар

Улс орон	2018 I-III		2019* I-III		2020* I-III	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн БНХАУ	1 482.4	100.0	1 771.7	100.0	1 035.8	100.0
Их Британи	1 301.7	87.8	1520.4	85.8	904.7	87.3
Швейцар	132.0	8.9	204.7	11.6	57.4	5.5
ОХУ	0.1	0.0	0.1	0.0	32.3	3.1
Сингапур	17.3	1.2	14.9	0.8	11.0	1.1
Бусад	8.0	0.5	7.4	0.4	5.8	0.6
	23.5	1.6	24.3	1.4	24.7	2.4

БНХАУ-д хийсэн экспорт нь манай улсын нийт экспортын дүнгийн 87.3 хувийг бүрдүүлж байна.

БНХАУ-д гаргасан бараа бүтээгдэхүүний 26.7 хувийг чулуун нүүрс, 38.8 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Их Британи улсад экспортолсон барааны 84.0 хувийг алт, ОХУ-д экспортолсон барааны 91.6 хувийг жоншны экспорт, Сингапур улсад экспортолсон барааны 51.7 хувийг чулуун нүүрс, эзэлж байна.

Зураг 5. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор, жил бүрийн эхний улирлын байдлаар



Экспорт 2020 оны эхний улиралд 1.0 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 735.9 (41.5%) сая америк доллароор буурсан байна. Нийт экспортын 85.5 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлдэг бөгөөд энэхүү бууралтад алтны экспорт 115.6 сая америк доллар, зэсийн баяжмалын экспорт 152.6 сая америк доллар, нүүрсний экспорт 391.3 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Монгол Улс эрсдэлийн бүс нутгаас хүнсний бүтээгдэхүүн импортлохгүй байх шийдвэр гаргасантай холбогдуулан 2020 оны эхний улиралд гахайн махыг 100 хувь, наранцэцэгийн тосны 95.6 хувийг ОХУ-аас импортолж, цагаан будааны 29.2 хувийг Вьетнамаас, 26.8 хувийг ОХУ-аас, 8.3 хувийг Казакстанаас, элсэн чихрийн 57.1 хувийг Тайландаас, 28.0 хувийг ОХУ-аас, 13.8 хувийг БНЭУ-аас тус тус импортолсон байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ургамлын тос, гахайн мах, элсэн чихрийн импорт 29.1-79.8 хувиар өсөж, харин цагаан будаа, өндөг, шувууны мах, жимс, жимсгэнэ, хуурай сүүний импорт 1.5-45.8 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 7.Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импорт, мян.ам доллар

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018 I-III		2019 I-III		2020* I-III		2020* I-III / 2019 I-III %	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Гурил	тонн	-	-	811.4	329.7	-	-	-	-
Улаан буудай	мян.тонн	110.6	21 817.7	-	-	14.7	2 811.6	-	-
Гахайн мах	тонн	2 143.1	2 727.6	475.4	868.5	697.5	1 651.3	146.7	190.1
Шувууны мах	тонн	1 951.0	3 586.4	2 544.4	5 286.7	2 106.8	3 966.3	82.8	75.0
Өндөг	сая.шир	31.2	2 264.9	32.6	2 277.5	31.8	2 113.5	97.6	92.8
Төмс	тонн	246.1	50.2	76.0	12.9	-	-	-	-
Хүнсний ногоо	мян.тонн	16.1	3605.7	17.2	3 414.4	17.6	3 335.7	102.6	97.7
Жимс, жимсгэнэ	тонн	5 888.2	4 315.2	6 840.2	5 344.7	4 858.1	4 161.1	71.0	77.9
Хуурай сүү	тонн	1 788.4	5 023.2	1 879.2	4 526.5	1 017.8	3 166.0	54.2	69.9
Цагаан будаа	тонн	8 428.1	5 166.5	5 860.8	3 232.2	5 775.2	3 032.5	98.5	93.8
Ургамлын тос	тонн	3 371.3	3 285.3	2 822.0	2 566.3	3 643.5	3 290.6	129.1	128.2
Элсэн чихэр	тонн	16 003.8	7 672.8	11 219.6	4 986.8	20 168.7	8 262.1	179.8	165.7

5. ААНБ, ИРГЭДЭД ОЛГОСОН НИЙТ ЗЭЭЛ

ААНБ, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3 дугаар сарын эцэст 17.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 200.9 (1.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 315.4 (1.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.6 (50.4%) их наяд төгрөг нь иргэдийн, 8.5 (49.6%) их наяд төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагынх байна.

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3 дугаар сарын эцэст 14.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 311.9 (2.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 519.7 (3.5%) тэрбум төгрөгөөр буурчээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 82.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр буурсан байна.

Хүснэгт 8. ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сарын эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2017 III	2018 III	2019 III	2020* III	2020* III / 2019 III
	тэрбум төгрөг				хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	12 678.5	14 139.5	17 461.9	17 146.5	98.2
Хэвийн зээл	10 647.9	11 971.8	14 683.0	14 163.3	96.5
Хугацаа хэтэрсэн зээл	995.1	935.9	913.7	1 150.3	125.9
Чанаргүй зээл	1 035.5	1 231.8	1 865.2	1 832.9	98.3

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 120.0 (11.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 236.6 (25.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 3 дугаар сарын эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 9.1 (0.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 32.3 (1.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй байна.

6. ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Валютын ханш өссөн боловч өмнөх онуудын 1, 2 дугаар сартай харьцуулахад өсөлтийн хувь саарсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 3 дугаар сард 2769.03 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар, өмнөх сараас 0.5 хувиар суларсан байна. 2020 оны 4 сарын 28-ны байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах дундаж ханш 2786.41 төгрөг байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 3 дугаар сард 394.57 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар, өмнөх сараас 0.1 хувиар суларсан байна. 2020 оны 4 сарын 28-ны байдлаар төгрөгийн юаньтай харьцах дундаж ханш 393.45 төгрөг байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2020 оны 2 дугаар сард 37.46 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар, өмнөх сараас 13.2 хувиар чангарсан байна. 2020 оны 4 сарын 28-ны байдлаар төгрөгийн рубльтэй харьцах дундаж ханш 37.48 төгрөг байна.

Хүснэгт 9. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах сарын дундаж ханш, төгрөгөөр, жил бүрийн 3 дугаар сард

Үзүүлэлт	2017 III	2018 III	2019 III	2020 I	2020 II	2020 III	2020.IV.28
Америк доллар	2 459.55	2 395.37	2 632.51	2744.38	2756.52	2769.03	2786.41
Жилийн өөрчлөлт,%	20.2	-2.6	9.9	3.6	4.7	5.2	
Сарын өөрчлөлт,%	-0.8	-0.3	-0.03	0.6	0.4	0.5	
Евро	2 631.77	2 954.35	2 979.59	3046.97	3010.28	3067.13	3022.56
Жилийн өөрчлөлт, %	15.7	12.3	0.9	0.6	0.7	2.9	
Сарын өөрчлөлт,%	-0.3	-0.4	-0.3	0.5	-1.2	1.9	
Юань	356.57	379.08	392.31	396.46	394.13	394.57	393.45
Жилийн өөрчлөлт,%	13.4	6.3	3.5	1.6	0.8	0.6	
Сарын өөрчлөлт,%	-1.1	-0.3	0.4	2	-0.6	0.1	
Рубль	42.51	41.96	40.49	44.34	43.15	37.46	37.48
Жилийн өөрчлөлт,%	45.7	-1.3	-3.5	11.9	7.8	-7.5	
Сарын өөрчлөлт,%	0.2	-0.8	1.2	2.2	-2.7	-13.2	

7. АЧАА БОЛОН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

ДЭМБ-аас онц байдал зарласнаар олон улсын нислэгүүд цуцлагдаж, улсууд гаднын иргэдийг нэвтрүүлэхгүй байх шийдвэр гаргаж, Монгол Улс ч хилээр орох, гарах урсгалыг хязгаарлаад зогсохгүй дотооддоо хөл хорио тогтоогоод байна. Үүнээс шалтгаалан улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний улиралд 10.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1 (33.4%) сая тонноор буурч, 29.1 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь 13.4 (31.4%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 5.6 (64.2%) сая тонноор, зорчигчид 13.2 (31.6%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.


Хүснэгт 10. Авто тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2017 I-III	2018 I-III	2019 I-III	2020* I-III
Тээсэн ачаа, сая тонн	7.5	7.3	8.8	3.1
Уул уурхайн бүтээгдэхүүн	6.7	6.5	7.9	2.5
Зорчигчид, сая хүн	44.3	46.4	41.6	28.5
Нийслэлийн нийтийн тээвэр	40.8	42.8	38.3	25.4
Тээврийн орлого, тэрбум төгрөг	119.4	135.8	160.9	85.9

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр 5.4 сая тонн буюу 68.4 хувиар, зорчигч тээврийн хувьд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 12.9 (33.7%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.


Авто тээврийн салбарын орлого 2020 оны эхний улиралд 85.9 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 75.0 (46.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 138.3 (61.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 6. Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Мөн түүнчлэн хот хоорондын хөл хорио тогтоосны улмаас төмөр замаар зорчигчдын тоо 2020 оны эхний улиралд 447.0 (давхардсан тоо) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 115.6 (20.5%) мянган хүнээр буурсан байна. Төмөр замын тээврээр зорчигчдын тоо буурахад орон нутгийн зорчигчид 108.4 (19.9%) мянган хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.

Зураг 7. Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр 2020 оны эхний улиралд давхардсан тоогоор 214.6 мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 85.7 (28.5%) мянган хүнээр буурсан байна. Агаарын тээврээр энэ оны 3 дугаар сард өмнөх сараас 34.8 (51.9%) мянган хүнээр бага буюу 32.2 мянган хүн зорчсон байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний улиралд 130.3 (60.7%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 74.2 (36.3%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 67.3 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 52.8 хувь, Улаанбаатар-Бангкок чиглэлийн зорчигчид 45.8 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 54.1 хувь, Улаанбаатар-Гонконг чиглэлийн зорчигчид 45.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний улиралд 51.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 40.8 (44.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

8. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Коронавируст халдвар (COVID-19) дэлхий дахинд гарсантай холбогдуулан Монгол Улсын хилийн боомтуудыг 2 дугаар сарын 1-ний өдрөөс хааж эхэлсэн. Энэ оны 2-р сард Монгол Улсын 31 иргэн агаарын боомтоор, 3939 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар орсон бол 3-р сард Монгол Улсын 1830 иргэн тусгай үүргийн нислэгээр, 296 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар тус тус ирсэн байна.


Хавирга боомтыг энэ оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс, Замын-Үүд, Баянхошуу, Бичигт, Булган, Гашуунсүхайд, Ханги, Шивээхүрэн боомтуудыг 2 дугаар сарын 1-ний өдрөөс, Бүянт-Ухаа боомтыг 2 дугаар сарын 15-ны өдрөөс, Алтанбулаг, Арц суурь, Боршоо, Тэс, Ульхан, Ханх, Цагааннуур, Сүхбаатар, Эрэнцав боомтуудыг 3 дугаар сарын 23-ний өдрөөс тус тус хаасан байна.

Манай улсын хилээр 2020 оны эхний улиралд 551.9 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 712.3 (56.3%) мянгаар буурчээ. Улсын хилээр орсон зорчигчдын 85.5% нь Монгол Улсын иргэд, 14.5% нь гадаад улсын иргэд байна.

Улсын хилээр 2020 оны эхний улиралд гадаадын 41.2 мянган хүн орсны 88.6% нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн байна. Аялал жуулчлалын зорилгоор хилээр орж ирсэн гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 38.9 (51.6%) мянгаар буурсан байна.

Коронавируст халдварын тархалт цаашид хэдий болтол үргэлжлэх нь тодорхой бус байна. Одоогийн байдлаар Монгол Улсын хилийн боомтуудыг 5 дугар сарыг дуустал нээхгүй байх шийдвэр гараад байна. Үүнээс шалтгаалан аялал жуулчлалын салбар нилээд хүнд байдалд орох нь тодорхой боллоо.

Зураг 8. Улсын хилээр орсон жуулчдын тоо, улирлаар



Гадаадын жуулчдын 2019 онд ирсэн улирлаар харвал 13.1 хувь нь I улиралд, 24.6 хувь нь II улиралд, 45.1 хувь нь III улиралд, 17.2 хувь нь IV улиралд ирж байжээ.


Аялал жуулчлалын салбарт 2019 оны байдлаар 1255 ААНБ үйл ажиллагаа эрхэлж байсан ба үүсээд буй нөхцөл байдлыг хохирол багатай давахын тулд эдгээр ААНБ-ууд дотоодын аялал жуулчлалын салбарт түлхүү анхаарах хэрэгтэй.

9. БИЗНЕС РЕГИСТР

Статистикийн бизнес регистрийн санд 2020 оны эхний улирлын байдлаар 190.5 мянган ААНБ бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 15.5 мянга буюу 8.9 хувиар, өмнөх улирлаас 3.4 мянга буюу 1.8 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Бүртгэлтэй ААНБ-ын 49.7 хувь нь үйл ажиллагаа явуулж, 50.3 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын нийт дүнд эзлэх хувь 0.5 пунктээр буурсан бол үйл ажиллагаа эхлээгүй байгаа ААНБ 1.6 пунктээр, үйл ажиллагаа бүрэг зогсоосон ААНБ 0.3 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 9. Хуулийн этгээдийн бүтэц, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар



Үйл ажиллагаа 2020 оны эхний улиралд явуулсан нийт ААНБ-ын 79.5 хувь (75.2 мянга), үйл ажиллагаа түр болон бүрэн зогсоосон ААНБ-ын 78.2 хувь (30.5 мянга) нь худалдаа, үйлчилгээний салбарынх байна.

Энэ оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс барилга, боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 9.2-10.3 хувиар нэмэгдсэн бол мэдээлэл, холбоо, үл хөдлөх хөрөнгө, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-ын тоо 4.4-5.8 хувиар буурсан байна.³

10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ажиллах хүчний судалгааны 2019 оны 4 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 12.9 хувь, тэр дундаа ажилгүйдлийн түвшин 8.1 хувь байсан байна.⁴

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 3 дугаар сарын эцэст 31.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.4 (10.8%) мянган хүнээр, өмнөх сараас 1.2 (6.1%) мянган хүнээр буурсан байна.

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 3 дугаар сарын эцэст ажилгүй 4.4 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 1.1 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 4.6 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 937 (17.5%) хүнээр, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 2.2 (32.4%) мянган хүнээр буурч, ажилд зуучлагдан орсон иргэд 220 (24.5%) хүнээр өсжээ. Ажил идэвхтэй хайхгүй байгаа иргэдийн тоо өсөж, шинээр ажил хайж байгаа иргэдийн тоо буурч байгаа нь иргэдийн ажил хайх идэвх суларч байгааг харуулж байна.

³ http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_2600_004V2

⁴ http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0400_020V2

Зураг 10. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 3 дугаар сарын эцэст



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 3 дугаар сард 4.4 мянган хүн шинээр бүртгүүлсний 58.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна. Тэдгээрийн 12.8 хувь нь орон тооны цомхотголд орсон бол 3.0 хувь нь байгууллага татан буугдсан шалтгаанаар ажил хайх болсон байна.⁵

11. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2020 оны эхний улиралд 5.3 мянган хүнд 12.9 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 225 (4.5%) хүнээр, олгосон тэтгэмжийн хэмжээ 3.9 (43.0%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчид 2020 оны эхний улиралд 723.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.6 хувь (18.7 мянга)-аар нэмэгдсэн бол сайн дураар даатгуулагчид 108.0 мянга болж, 22.4 хувь (31.1 мянга)-аар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны эхний улиралд 678.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 38.3 (6.0%) тэрбум төгрөг, зарлага 649.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 75.0 (13.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 47.2 (10.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн бол нийгмийн даатгалын сангийн зарлага өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 75.4 (17.0%) тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 8.2 (28.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн халамжийн сангаас 2020 оны эхний улиралд 331.5 мянган хүнд 76.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 8.5 (2.6%) мянгаар өсөж, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 12.4 (19.4%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авсан хүний тоо нэмэгдэхэд "Нийгмийн халамжийн тэтгэмж" авсан хүний тоо 8.0 (11.1%) мянгаар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж авагчид энэ оны эхний улиралд 27.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 4.5 (19.4%) мянга, олгосон тэтгэмжийн хэмжээ 6.6 тэрбум төгрөг болж, 1.7 (33.7%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.


⁵ МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал 2020/3

http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Bulletin_2020_3_mn.pdf&ln=Mn

12. ЭРҮҮЛ МЭНД

Энэ оны эхээр ханиад, томуугийн өвчлөл оргилдоо хүрч, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх жилүүдийнхээс нэмэгдсэн. БНХАУ-д "Ковид-19"-ийн халдвар дэгдсэнтэй холбоотойгоор манай улс өнгөрсөн нэгдүгээр сарын 27-ноос бүх төрлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт намжиж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буураад байна.

Зураг 11. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, мянган хүн



Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид 2020 оны эхний улиралд 225.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.6 (1.5%) мянган хүнээр буурсан бол энэ оны 3 дугаар сард 67.6 мянган хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, өмнөх сараас 3.5 (4.9%) мянган хүнээр, өмнөх оны мөн үеэс 16.7 (19.8%) мянган хүнээр буурсан байна.

Хүснэгт 11. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2019 I-III	2020 I-III	2020 I-III / 2019 I-III %
Халдварт өвчнөөр өвчлөгчид	10 155	9 434	92.9
Цусаар дамжих	118	119	100.8
Вирусст гепатит	118	119	100.8
Амьсгалын замаар дамжих	4 185	2 634	62.9
Сүрьеэ	860	870	101.2
Салхин цэцэг	2 936	1 579	53.8
Гар, хөл, амны өвчин	389	185	47.6
Гэдэсний халдварт	892	397	44.5
Цусан суулга	892	397	44.5
Бэлгийн замаар дамжих	3 760	4 883	129.9
Тэмбүү	1 361	1 942	142.7
Гонококкт халдвар	1 361	1 517	111.5
Трихомониаз	1 036	1 422	137.3
ХДХВ/ДОХ	2	2	100.0
Бусад	427	1 118	261.8
Мөөгөнцөр	427	1 106	259.0
Коронавируст халдвар	-	12	-

Эх үүсвэр: ЭМЯ

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2020 оны эхний улиралд 9434 болж, өмнөх оны мөн үеэс 721 (7.1%)-ээр буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварын замын төрлөөр харвал амьсгалын замаар дамжих халдварын тохиолдол 2634 болж, 1551 (37.1%)-ээр, гэдэсний халдварт өвчин 397 болж, 495 (55.5%)-аар тус тус буурсан байна.

Иргэд ЭМЯ-ны заавар, зөвлөгөөг сайн дагаж, гараа тогтмол угаан, амны хаалт зүүж хэвшсэн нь амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин урьд байгаагүй доод түвшинд хүрч, буурахад нөлөөлсөн байна.

Харин бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 4883 болж, 1123 (29.9%)-аар нэмэгдсэн байна.

13. ГЭМТ ХЭРЭГ

Монголд хөл хорио тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжээд 3 сар өнгөрч байна. Үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудыг хэсэгчлэн хааж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан мөн иргэдийг аль болох гэртээ байхыг уриалж байгаа нь энэ хугацаанд нийт гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 оны эхний улиралд 8003 болж, өмнөх оны мөн үеэс 1902 (19.2%)-оор буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 оны 3 дугаар сард 2059 болж, өмнөх сараас 1314 (39.0%)-өөр буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020 оны эхний улиралд 26 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 133 (83.6%)-аар буурсан байна.

Гэвч нөгөө талдаа гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нэмэгдэх шалтгаан болж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2020 оны эхний улиралд 3131 зөрчил бүртгэгдсэний 2244 (71.7%) зөрчлийг шалган шийдвэрлэсэн байна. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 1193 (61.6%)-аар, шийдвэрлэсэн зөрчил 1118 (99.3%)-аар тус тус өссөн байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2020 оны эхний улиралд 799 болж, өмнөх оны мөн үеэс 36 (4.7%)-гаар өсөж, улсын хэмжээнд 27.1 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 3.6 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 1.7 (6.0%) мянгаар буурч, харин баривчлагдсан хүн 1.0 (39.8%) мянгаар өссөн байна.

ДҮГНЭЛТ

Шинэ он гарснаас хойш тасралтгүй үргэлжилж байгаа байгалийн гамшиг, аюул осол, халдварт өвчний дэгдэлт нь дэлхийн эдийн засгийг нэлээд тодорхой бус байдалд хүргэж байна.

Манай улсын эдийн засгийн идэвх өвлийн улиралд сулардаг бөгөөд олон жилийн ажиглалтаар оны эхний улиралд үйлдвэрлэл, борлуулалт саарч, татварын орлого буурах хандлагатай байдаг. Ялангуяа махны эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалсан инфляц нэмэгддэг. Үүнтэй зэрэгцэн энэ онд Ковид-19 буюу коронавирусын халдварын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээнээс шалтгаалан Монгол Улсын экспорт, импортын хэмжээ саарч, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого буураад байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 2.2 их наяд төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого буурахад бусад татвар, төлбөр хураамжийн орлого 63.9 (29.9%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 33.9 (15.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Энэ оны эхний улиралд автобензин, дизелийн түлш, суудлын автомашины импорт буурсан нь онцгой албан татварын орлого буурахад голлон нөлөөлсөн байна.

Мөн улсын нэгдсэн төсвийн гуравны нэгийг бүрдүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 41.5 хувиар буурсан нь төсвийн орлого тооцоолсон хэмжээнд хүрэхгүй болох эрсдэлийг дагуулж байна.

Дэлхий нийтийг хамраад буй халдварт өвчний тархалт манай улсын үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж эхэлж байна. Нэн ялангуяа үйлдвэрлэлийн түүхий эд, материал болон сэлбэг, эд ангиа гаднаас импортолдог резин болон хуванцар бүтээгдэхүүн, мод, модон эдлэл, химийн бүтээгдэхүүн, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас, машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, тавилга үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 7.8 хувиас 44.8 хувиар буураад байна.

Үүнтэй уялдаад банкны системийн хэмжээгээр хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар өсөөд байна.

Харин халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлж хөл хорио тогтоогоод буй энэ үед дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид хүнсний бүтээгдэхүүний тасалдал үүсгэхгүй төлөө хичээл зүтгэл гарган ажиллаж, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны эхний улиралд 385.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 28.6 (8.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ДЭМБ-аас онц байдал зарласны дагуу хилээр орох, гарах урсгалыг хязгаарласны дээр дотоодын хөл хорионы улмаас улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний улиралд 10.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1 (33.4%) сая тонноор буурч, 29.1 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь 13.4 (31.4%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 5.6 (64.2%) сая тонноор, зорчигчид 13.2 (31.6%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дийлэнх хувийг бүрдүүлдэг нүүрсний тээврийг автозамаар тээвэрлэдэг ба энэ он гарснаас хойш БНХАУ-руу экспортолж буй нүүрсний хэмжээ огцом буурсан нь авто тээврээр тээсэн ачаа буурахад голлох нөлөөг үзүүлсэн байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 28.1% буурсан нь БНХАУ-тай хийсэн нийт экспорт 40.5 хувиар, импорт 9.7 хувиар буурсантай холбоотой байна.

Валютын ханш өссөн боловч өмнөх онуудын 1, 2 дугаар сартай харьцуулахад өсөлтийн хувь саарсан байна.

Хаврын улиралд махны эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалсан үнийн өсөлт болон импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн удаашралтай холбоотой инфляцын түвшин өсөх хандлагатай байна.

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын 49.7 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын нийт дүнд эзлэх хувь 0.5 пунктээр буурсан бол үйл ажиллагаа эхлээгүй байгаа ААНБ 1.6 пунктээр, үйл ажиллагаа бүрэг зогсоосон ААНБ 0.3 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

Коронавирусны эсрэг хэрэгжүүлж арга хэмжээ үл хөдлөх хөрөнгө, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-д илүү сөрөг нөлөөлсөн нь эдгээр салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 4.4-5.8 хувиар буурснаас харагдаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2020 оны 3 дугаар сард шинээр бүртгүүлсэн хүмүүсийн 58.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан байна. Тэдгээрийн 12.8 хувь нь орон тооны цомхотголд орсон бол 3.0 хувь нь байгууллага татан буугдсан шалтгаанаар ажил хайх болсон байна. Ажил идэвхтэй хайхгүй байгаа иргэдийн тоо өсөж, шинээр ажил хайж байгаа иргэдийн тоо буурч байгаа нь цар тахлын тархалтын эсрэг хэрэгжүүлж буй хөл хорио иргэдийн ажил хайх идэвхийг сулруулж байгааг харуулж байна.

Энэ оны нэг, хоёрдугаар сард ханиад, томуугийн өвчлөл оргилдоо хүрч, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх жилүүдийнхээс нэмэгдэж байсан бол БНХАУ-д "Ковид-19"-ийн халдвар дэгдсэнтэй холбоотойгоор манай улс бүх шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт намжиж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буураад байна.

Иргэд ЭМЯ-ны заавар, зөвлөгөөг сайн дагаж, гараа тогтмол угаан, амны хаалт зүүж хэвшсэн нь амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин урьд байгаагүй доод түвшинд хүрч, буурахад нөлөөлсөн байна.

Үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудыг хэсэгчлэн хааж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, иргэдийг аль болох гэртээ байхыг уриалж байгаа нь хөл хорио тогтоогоод буй хугацаанд нийт гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн байна.

Гэвч нөгөө талдаа гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нэмэгдэх шалтгаан болж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 61.6 хувиар өссөн байна.